



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/59

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал илэрч сумын хэмжээнд гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн нөхцөл байдалтай холбогдуулан сумын Засаг даргын Тамгын газарт автомашины нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: З.Цэцэгмаа - Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Д.Уранчимэг - Санхүүгийн албаны дарга

Л.Цэдэв – Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын онцгой журамын дагуу гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, гэрээний төслийг танилцуулахыг ажлын хэсэг (З.Цэцэгмаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ